



**Зүүн хойд Азийн
ХОТЫН ДАРГА НАРЫН ФОРУМ**

Нүүрстөрөгч багатай хотуудын хөгжил:

**Агаарын чанарыг сайжруулж,
хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах нь**

УЛААНБААТАР 2018.06.18-19





ХОЛБОО БАРИХ:

Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар
Монгол Улс, Улаанбаатар хот,
Чингэлтэй дүүрэг, Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит талбай 7

Утас: + 976 (11) 32-96-59

Цахим хуудас: www.ulaanbaatar.mn



МЭНДЧИЛГЭЭ

Ноён Сундуйн Батболд

Нийслэлийн Засаг дарга бөгөөд
Улаанбаатар хотын Захирагч



Эрхэм хүндэт зочдоо,

Та бүхнийг “Нүүрстөрөгч багатай хотуудын хөгжил: Агаарын чанарыг сайжруулж, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах нь” сэдвийн дор зохиогдож буй 3 дахь удаагийн Зүүн хойд Азийн хотын дарга нарын форумд оролцож байгаад чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Энэ удаагийн форумд Зүүн хойд Азийн бүс нутгийн 6 улсын, 18 хотын дарга, шийдвэр гаргагчид, олон улсын байгууллагын нийт 300 гаруй төлөөлөгчид дэлхий нийтийн өмнө тулгарч буй уур амьсгалын өөрчлөлт, түүний үндсэн шалтгаан болсон хүлэмжийн хийн ялгарлыг хотын төвшинд бууруулах арга замуудыг хэлэлцэж, туршлага солилцохоор хуран цуглараад байна.

Өнөөгийн байдлаар хот суурин газрууд нийт хүлэмжийн хийн 70 гаруй хувийг ялгаруулж байна. Иймд дэлхийн агаарын дундаж температурын өсөлтийг аж үйлдвэрийн өмнөх үетэй харьцуулахад 2 Цельсийн градусуаас доош барих, агаарын температурын өсөлтийг 1.5 Цельсийн градууст хязгаарлах олон улсын зорилгод хүрэхэд хотуудын үүрэг, оролцоо маш чухал юм.

Форумын хүрээнд нүүрстөрөгчийн ялгарал багатай хотын хөгжлийг бий болгох, хотуудын байгаль орчны тулгамдсан асуудлууд, тэр дундаа агаарын бохирдлыг бууруулах зорилгын хүрээнд бүс нутгийн хотуудын хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааны талаар мэдээлэл солилцохоос гадна байгалийн нөөц бага ашигладаг, бүтээмж өндөр технологийн шийдлүүдийг хотууд хэрхэн нэвтрүүлж байгаа туршлагын талаар сонсож, харилцан ярилцах боломж бүрдэнэ. Мөн Зүүн хойд Азийн хотын дарга нарын форумын үйл ажиллагааг цаашид идэвхжүүлж, байнгын үйл ажиллагаатай механизм болгон өргөжүүлэх талаар оролцогч хотууд хоорондоо санал солилцож, өөрсдийн үзэл бодлыг нээлттэй хуваалцах юм.

Сөрөг нөлөөлөл нь жилээс жилд мэдэгдэхүйц нэмэгдэж буй уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах дэлхийн нийтийн зорилгод хүрэхэд бүс нутгийн, түүний дотор хотуудын оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хамтын ажиллагааны эх суурь энэхүү форумгаар тавигдана гэдэгт итгэлтэй байна.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ

A handwritten signature in black ink, appearing to read 'Sunduyin Batbold'.

С.БАТБОЛД

ХӨТӨЛБӨР

Улаанбаатар хот, 2018.06.17-19

2018.06.17 НЯМ ГАРАГ

- 06:00 - 19:00 **Гадаадын зочид төлөөлөгчдийг угтан авах**
Шангри-Ла зочид буудал
- 19:00 - 21:00 **УГТАЛТЫН ХҮЛЭЭН АВАЛТ**
Моне ресторан, Сэнтрал Тауэр, 17 давхар

2018.06.18 ДАВАА ГАРАГ

Байршил: Шангри-Ла зочид буудлын Их танхим

- 08:30 - 09:00 **Бүртгэл**
- 09:00 - 10:20 **ФОРУМЫН НЭЭЛТ**
- 09:05 - 09:15 **Нээлтийн үг:**
Сундуйн Батболд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч
- 09:15 - 09:25 **Мэндчилгээ:**
Ухнаагийн Хүрэлсүх, Монгол Улсын Ерөнхий сайд
Намсрайн Цэрэнбат, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
- 09:25 - 09:55 **Хотуудын төлөөлөгчдийн мэндчилгээ**
Жан Чин, БНХАУ-ын Бээжин хотын Ардын төлөөлөгчдийн хурлын Байнгын хорооны орлогч дарга
Жун-Бён Юн, БНСУ-ын Сөүл хотын Захиргааны асуудал хариуцсан дэд дарга
Александр М. Голков, ОХУ-ын Улаан-Үд хотын дарга
Юү Жү Ёон, БНАСАУ-ын Солонгос - Ази, Номхон далайн орнуудын хамтын ажиллагааны нийгэмлэгийн нарийн бичгийн дарга
Наобүми Хигашикава, Япон Улсын Токио хотын Байгаль орчны газрын Уур амьсгалын өөрчлөлт ба эрчим хүчний хэлтсийн дарга
Алекс Хайкенс, Монгол дахь НҮБ-ын Хүүхдийн Сангийн Суурин төлөөлөгч

- 09:55 - 10:05 **Дурсгалын зураг авахуулах**
- 10:05 - 10:20 **Цайны завсарлага**
- 10:20 - 12:30 **НЭГДҮГЭЭР ХУРАЛДААН:
НҮҮРСТӨРӨГЧ БАГАТАЙ НОГООН ХӨГЖЛИЙГ БИЙ
БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР ХОТУУДЫН БАРИМТАЛЖ БҮЙ
БОДЛОГО, ТУЛГАРЧ БҮЙ БЭРХШЭЭЛҮҮД**
- 10:20 - 10:30 **Хуралдааны нээлт**
*Даргалагч: Марк Кэйниг, Азийн сангийн Монгол дахь
Суурин төлөөлөгч*
- 10:30 - 10:45 **Үндсэн илтгэл**
**Орон нутгийн засаг захиргаад хоорондын хамтын
ажиллагаа**
*Ман Чи Лао, Тогтвортой байдлын төлөөх орон нутгийн
захиргаадын олон улсын байгууллагын Зүүн Азийн
бүсийн Нарийн бичгийн даргын газрын хөтөлбөрийн
менежер*
- 10:45 - 11:00 **Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулж,
хүлэмжийн хийн ялгарлыг багасгах чиглэлээр
хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа**
*Жанцангийн Батбаясгалан, Нийслэлийн Засаг
даргын Ногоон хөгжил, агаарын бохирдлын асуудал
хариуцсан орлогч*
- 11:00 - 11:15 **Бээжин хотын агаарын бохирдлын хяналтын тойм:
2013-2017**
*Жан Чин, БНХАУ-ын Бээжин хотын Ардын төлөөлөгчдийн
хурлын Байнгын хорооны орлогч дарга*
- 11:15 - 11:30 **Сөүл хотын агаарын чанарын хяналтын бодлогууд**
*Кихюүн Ким, БНСУ-ын Сөүл хотын захиргааны Гадаад
харилцааны газрын дарга*
- 11:30 - 11:45 **Токио хотын нүүрстөрөгчийг бууруулах санаачлагууд**
*Наобүми Хигашикава, Япон улсын Токио хотын Байгаль
орчны газрын Уур амьсгалын өөрчлөлт ба эрчим
хүчний хэлтсийн дарга*
- 11:45 - 12:00 **Москва хотын уур амьсгалын бодлогын тэргүүлэх
чиглэлүүд**
П.В.Захарова, ОХУ-ын Москва хотын Байгаль орчныг

хамгаалах хүрээлэнгийн захирал

12:00 - 12:20

Асуулт, хариулт

12:20 - 12:30

Нэгдүгээр хуралдааны хаалт, дүгнэлт

Марк Кэйниг, Азийн сангийн Монгол дахь Суурин төлөөлөгч

12:30 - 14:00

ӨДРИЙН ХООЛ

Шангри-Ла, 1 давхар, Кафе парк ресторан

Өдрийн хоолны үеэр хуралдааны танхимын лобби хэсэгт “Би+д өөрөөсөө эхэлье” хотжилтоос үүдэлтэй байгаль орчны тулгамдсан асуудлуудыг үзүүлсэн зурагт хуудасны үзэсгэлэнтэй танилцах

14:00 - 18:00

**ХОЁРДУГААР ХУРАЛДААН:
НҮҮРСТӨРӨГЧ БАГАТАЙ ХОТУУДЫН ТЕХНОЛОГИЙН
ШИЙДЛҮҮД БА САЙН ТУРШЛАГУУД**

14:00 - 14:10

Хуралдааны нээлт

Даргалагч: Санжаасүрэнгийн Оюун, Уур амьсгалын ногоон сангийн Гадаад харилцаа хариуцсан захирал

14:10 - 14:30

Үндсэн илтгэл:

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах арга зам, технологийн шийдлүүд

Санжаасүрэнгийн Оюун, Уур амьсгалын ногоон сангийн Гадаад харилцаа хариуцсан захирал

14:30 - 14:45

“Улаанбаатар хотын иргэдийн орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл” төслийн танилцуулга

Арнауд Хэкманн, Азийн хөгжлийн банкны Хотын хөгжил хариуцсан ахлах мэргэжилтэн

14:45 - 15:00

Шэньян хотын нүүрстөрөгч багатай хөгжлийн шийдэл ба асуудлууд

Жау Юншэнг, БНХАУ-ын Шэньян хотын Ардын Засгийн газрын Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч

15:00 - 15:15

Тэжон хотыг агаарын чанарын загвар хот болгох арга зам

Еүнчүл Лий, БНСУ-ын Тэжон хотын Олон улсын харилцааны асуудал эрхэлсэн Элчин сайд

- 15:15 - 15:35 **Асуулт, хариулт**
- 15:35 - 15:55 **Цайны завсарлага**
- 15:55 - 16:10 **Чита хотын гадаад орчны агаарын төлөв байдал:
Агаарын бохирдлын асуудлыг шийдвэрлэх арга
замууд**
Олег Кузнецов, ОХУ-ын Чита хотын дарга
- 16:10 - 16:25 **Хятадын нүүрстөрөгч багатай, ногоон хотууд: Ололт
амжилт ба цаашдын төлөв**
*Ху Мин, Инноваци ба ногоон хөгжлийн хөтөлбөрийн
гүйцэтгэх захирал*
- 16:25 - 16:40 **Сувон хотын “Эко-мобилити” төслийн хэрэгжилт**
*Жае Ёүн Лий, БНСУ-ын Сувон хотын Судалгааны
хүрээлэнгийн ерөнхийлөгч*
- 16:40 - 16:55 **“Монгол улсын барилгын салбарын хүлэмжийн хийн
ялгарлыг бууруулах үндэсний арга хэмжээ” төслийн
танилцуулга**
*Бямбаагийн Баярлахам, Нэгдсэн Үндэстний
Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн төслийн
зохицуулагч*
- 16:55 - 17:10 **Улаан-Үд хотын гадаад орчны агаарыг сайжруулах
чиглэлээр хэрэгжүүлж буй гол үйл ажиллагаанууд**
Александр М. Голков, ОХУ-ын Улаан-Үд хотын дарга
- 17:10 - 17:25 **Нүүрстөрөгч багатай хот: Бүтээн байгуулалт ба
менежмент**
*Си Жэн, БНХАУ-ын Тяньжин хотын Байгаль хамгаалах
газрын дэд дарга*
- 17:25 - 17:45 **Асуулт, хариулт**
- 17:45 - 18:00 **Хоёрдугаар хуралдааны хаалт, дүгнэлт**
*Санжаасүрэнгийн Оюун, Үур амьсгалын ногоон
сангийн Гадаад харилцааны асуудал хариуцсан
захирал*
- 18:30 - 20:30 **НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧИЙН ХҮЛЭЭН АВАЛТ**
Шангри-Ла зочид буудал, Их танхим

2018.06.19, МЯГМАР ГАРАГ

Байршил: АСЕМ Вилла, Их гэр

- 08:00 **Зочид буудлаас хөдлөх**
- 09:00 - 11:20 **ГУРАВДУГААР ХУРАЛДААН:
ЗҮҮН ХОЙД АЗИЙН ХОТЫН ДАРГА НАРЫН ФОРУМЫН
ЦААШДЫН АЛХАМ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АСУУДАЛ**
- 09:00 - 09:10 **Хуралдааны нээлт**
Даргалагч: Жанцангийн Батбаясгалан, Нийслэлийн Засаг даргын Ногоон хөгжил, агаарын бохирдлын асуудал хариуцсан орлогч
- 09:10 - 09:30 **Үндсэн илтгэл**
Зүүн хойд Азийн хотын дарга нарын форумыг байнгын үйл ажиллагаатай мөханизм болгох нь
Сүрэнгийн Бадрал, Форум зохион байгуулах ажлын хэсгийн зөвлөх
- 09:30 - 10:30 **Хэлэлцүүлэг:**
- Форумын төгсгөлийн баримт бичгийг хэлэлцэх
- Форумын Нарийн бичгийн даргын газар байгуулах
- 10:30 - 10:40 **Хэлэлцүүлгийн дүгнэлт**
- 10:40 - 11:00 **Зүүн хойд Азийн хотын дарга нарын 4 дэх удаагийн форумыг зохион байгуулах санал ирүүлсэн хотуудын танилцуулга, санал хураалт**
БНСУ-ын Сөүл хот, БНХАУ-ын Чанчунь хотын төлөөлөгчид
- 11:00 - 11:10 **Форумын төгсгөлийн баримт бичгийг танилцуулж, Зүүн хойд Азийн хотын дарга нарын 4 дэх удаагийн форумыг зохион байгуулах хотын нэрийг зарлах**
Жанцангийн Батбаясгалан, Нийслэлийн Засаг даргын Ногоон хөгжил, агаарын бохирдлын асуудал хариуцсан орлогч
- 11:10 - 11:20 **Форумын хаалт**
Сундуйн Батболд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч
- 11:20 - 11:40 **Хэвлэлийн бага хурал**
АСЕМ Вилла, Их гэр

- 11:40 - 12:00 **Завсарлага**
- 12:00 - 13:00 **Өдрийн хоол**
АСЕМ Вилла, Их гэр
- 13:00 - 13:30 **Зочид буудалд ирэх**
Шангри-Ла зочид буудал
- 13:30 - 14:30 **Зочид буудалдаа амрах**
- 14:30 - 15:30 **Д.Сүхбаатарын талбайд дурсгалын зураг авахуулах,
Төрийн түүхийн музей үзэх**
- 15:30 - 17:30 **Говь ХК-ийн үйлдвэртэй танилцах, үйлдвэрийн дэргэдэх
төв дэлгүүрээр зочлох**
Чингисийн өргөн чөлөө, Үйлдвэрчний гудамж
- 17:30 - 18:00 **“Чингисийн хүрээ” цогцолборт ирэх**
- 18:00 - 21:00 **Оройн зоог, Бэсрэг наадам**
“Чингисийн хүрээ” цогцолбор
- 21:00 **Хөтөлбөр өндөрлөх**

2018.06.20, ЛХАГВА ГАРАГ

- 06:00 - 00:00 **Буцах хуваарийн дагуу зочид төлөөлөгчдийг үдэн
гаргах**

**ЗҮҮН ХОЙД АЗИЙН ХОТЫН ДАРГА НАРЫН ФОРУМ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ**





Ноён Сундуйн Батболд

Нийслэлийн Засаг дарга бөгөөд
Улаанбаатар хотын Захирагч

Ноён С.Батболд нь 2016 оноос Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаар ажиллаж байна. Уг албан тушаалд томилогдохоосоо өмнө Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга, Улсын Их Хурал дахь Монгол Ардын Намын бүлгийн дэд дарга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар тус тус ажиллаж байсан туршлагатай. Тэрбээр 2002-2016 онд УИХ-ын гишүүнээр сонгогдон ажиллаж байсан.

С.Батболд нь Хөдөө Аж Ахуйн Их Сургууль, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийг бакалавр зэрэгтэй төгссөн бөгөөд Хөдөө Аж Ахуйн Их Сургуульд Техникийн ухааны магистрын зэрэг, Удирдлагын Академид Төрийн захиргааны менежментийн докторын зэрэг хамгаалсан.



Ноён Намсрайн Цэрэнбат

Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн,
Байгаль орчин, аялал жуулчлалын сайд

Н.Цэрэнбат нь Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын албан тушаалыг хашдаг. Тэрбээр 2016 оноос Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байна. 2010-2012 онд Монгол Улсын Их хурлын Тамгын газарт ажиллаж байсан.

Өмнө нь “Юу Эф Си” группд гүйцэтгэх захирал, Сангийн яамны Төсвийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга, “Трансинконсулт” ХХК-д гүйцэтгэх захирал, “Увс хүнс” ХХК-ийн дэд захирал, Таван Богд групп, Мобиком корпорацид тус тус ажиллаж байсан.

Н.Цэрэнбат нь Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Компьютер техник менежментийн сургуулийг санхүүгийн менежментийн бакалавр, магистрын зэрэгтэй дүүргэсэн.



НЭГДҮГЭЭР ХУРАЛДААН: НҮҮРСТӨРӨГЧ БАГАТАЙ НОГООН ХӨГЖЛИЙГ БИЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР ХОТУУДЫН БАРИМТАЛЖ БҮЙ БОДЛОГО, ТУЛГАРЧ БҮЙ БЭРХШЭЭЛҮҮД



Ноён Марк Кэйниг

Азийн сангийн Монгол дахь Суурин төлөөлөгч

Азийн сангийн Монгол дахь Суурин төлөөлөгч Ноён Марк Кэйниг нь Азийн улс орнуудад хотжилт, засаглалын асуудлаар сүүлийн 10 гаруй жил тасралтгүй ажиллаж байгаа бөгөөд Монголд томилогдохоос өмнө Азийн сангийн хөтөлбөр хариуцсан газарт хотын засаглалын мэргэжилтэн (Urban Governance Specialist), Дэд даргын албан тушаалыг хашиж байсан. Азийн сангийн Бангкок дахь бүсийн оффист ажиллах явцдаа Монгол, Камбож, Балба, Мьянмар зэрэг улсуудад хотын засаглал, үйлчилгээг сайжруулах чиглэлийн төсөл, хөтөлбөрийг санаачлан, хэрэгжүүлэхэд зөвлөгөө, дэмжлэг үзүүлэн ажиллаж байсан туршлагатай.

Тэрбээр Швейцарын Женевт байрлах Олон улсын аюулгүй байдлын зөвлөх багт ажиллаж байгаад 2010 онд Азийн санд орж иргэдийн оролцоо, хяналт, авлига, ил тод байдал, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр Балба, Афганистан, Зүүн Тимор, Монгол зэрэг улсуудад ажиллаж байжээ.

Тэрбээр 2013 онд Азийн сангийн Хөтөлбөр, стратеги шинэчлэл, сургалтын газрын дэд даргаар томилогдож стратеги төлөвлөлтийн асуудлыг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд Австрали Улсын Засгийн газартай хамтын ажиллагааг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажилласан байна. Марк АНУ-ын Жон Хопкинсийн их сургуулийг улс төр судлаач мэргэжлээр төгсөж, Тафтс их сургуулийн Флетчер сургуульд Олон улсын хууль ба дипломатын чиглэлээр магистрын зэрэг хамгаалжээ.

Азийн сангийн Монгол дахь Суурин төлөөлөгчийн газар нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, дүүрэг, хороодтой хамтран хотын засаглалыг бэхжүүлэх, иргэдийн оролцоог дэмжих, нийтийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр ажилладаг бөгөөд 2014 оноос хойш Зүүн Хойд Азийн Хотын дарга нарын форумыг Улаанбаатар хотноо зохион байгуулахад техникийн дэмжлэг, тусалцаа үзүүлэн, хамтран ажилласаар ирсэн.

Ноён Ман Чи Лао (Мерлин)

**Хөтөлбөрийн менежер
Тогтвортой байдлын төлөөх орон нутгийн захиргаадын
олон улсын байгууллагын Зүүн Азийн бүсийн
Нарийн бичгийн даргын газар**



Мерлин Хонконг дахь Хятадын их сургуулийн Химийн шинжлэх ухааны бакалавр зэрэгтэй бөгөөд хожим нь Эдинбургийн их сургуульд Тогтвортой эрчим хүчний тогтолцоогоор магистрын зэрэг хамгаалжээ. 2016 оноос одоог хүртэл Тогтвортой байдлын төлөөх орон нутгийн захиргаадын олон улсын байгууллагын Зүүн Азийн нарийн бичгийн даргын газрын хөтөлбөрийн багийг ахлан ажиллаж байна. Тодруулбал Хятад, Япон, Солонгос, Монголын 90 гаруй хотуудад хотын хөгжлийн хөтөлбөр боловсруулах ажлыг хариуцаж байгаа юм. Тэр дундаа Хятад, Монгол улсад олон төслүүд хэрэгжүүлж байсан арвин туршлагатай. Мерлин гол төлөв байгаль орчин, нүүрстөрөгчийн ялгарал багатай бүтээн байгуулалт, ногоон эдийн засгийн өсөлт нэмэгдүүлэх зорилготой төслүүдийг удирддаг.

Тогтвортой байдлын төлөөх орон нутгийн захиргаадын олон улсын байгууллагын Зүүн Азийн салбарт ажиллахаас өмнө тэрбээр Макаогийн Байгаль орчин хамгаалах товчоонд ахлах мэргэжилтний албыг 4 жил хашжээ. Энэ хугацаандаа Макаогийн тусгай захиргааны бүсийн эхний 10 жилийн байгаль орчны төлөвлөлт болон олон улсын байгаль орчны гэрээ хэлэлцээрүүдийг дагаж мөрдөх ажлыг хариуцдаг байв. Мөн тэрбээр PECET Карбон компанид техникийн зөвлөхөөр ажиллаж байсан туршлагатай. Тус компани нь Хонконг болон Тайландад салбартай, Их Британид шинжлэх ухааны академийн хүрээлэнтэй, дэлхийд тэргүүлэх, тогтвортой эрчим хүчний удирдлагын зөвлөх компани юм.


ОРОН НУТГИЙН ЗАСАГ ЗАХИРГААД ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Энэхүү чуулга уулзалт нь агаарын чанарыг сайжруулах болон хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах дээр гол анхаарлаа хандуулна. Бидний дүгнэж байгаагаар хотуудад тулгарч буй томоохон бэрхшээлүүд нь тууштай, тогтвортой, үр дүнтэй арга хэмжээ боловсруулаагүй, үр дүн, амжилтыг хэмжих чадвар, тогтолцоо дутмаг, улс төр болон газар зүйн байрлалын улмаас хамтын ажиллагааг зохион байгуулах зэрэгт хүндрэлтэй байгаад оршиж байна. Тогтвортой байдлын төлөөх орон нутгийн захиргаадын олон улсын байгууллагын Олон улсын зөвлөлийн зүгээс орон нутгийн засаг захиргаад нүүрстөрөгч багатай бүтээн байгуулалтын үйл явцыг хүрдасгахад бие биенээсээ суралцаж, мэдлэг туршлагаасаа хуваалцаж мөн өөрсдийн амжилт гүйцэтгэлийг бусад хотуудтай харьцуулах нь маш чухал гэж үзэж байна. Мөн манай бүс нутгийн хувьд агаарын болон уур амьсгалын бохирдлын эх үүсвэр, бохирдуулагчийн талаарх дүр зураг, ойлголт, харах өнцөг зэрэг нь барууны улс орнуудаас ялгардаг гэдгийг анхаарах нь зүйтэй. Зүүн Хойд Азийн хотуудын хувьд агаарын бохирдол нь уур амьсгалын өөрчлөлттэй харьцуулахад нэн тулгамдсан асуудал юм. Тийм ч учраас бодлого төлөвлөлт болон хамтын ажиллагаанд дээрх ялгааг авч үзэх ёстой.

Энэхүү хэлэлцүүлгээр бид дээр дурдсан хүндрэл бэрхшээл болон эдгээрийг шийдэх Тогтвортой байдлын төлөөх орон нутгийн захиргаадын олон улсын байгууллагын Олон улсын зөвлөлийн арга замуудыг ярилцах бөгөөд хоёр төслийг жишээ болгон танилцуулна. Тус хоёр төсөл нь уур амьсгалын өөрчлөлт, агаарын чанарыг сайжруулахад чиглэсэн юм.

Хэлэлцүүлгийн зорилтууд:

- Хотуудад тулгарч буй бодлогын шинж чанартай хүндрэл бэрхшээлүүд
- Уур амьсгалын өөрчлөлт болон агаарын бохирдлын холбоо, хамаарал
- Үр дүнтэй бүс нутгийн хамтын ажиллагаа
- Хотуудад зориулсан системчилсэн зохион байгуулалттай арга хэмжээнүүд



Ноён Жанцангийн Батбаясгалан

Нийслэлийн Засаг даргын Ногоон хөгжил,
агаарын бохирдлын асуудал хариуцсан орлогч

Ж.Батбаясгалан нь эрх зүйч мэргэжилтэй. 2004 - 2008 онд УИХ-ын Тамгын газарт, 2008 - 2012 онд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, 2008 - 2012 онд Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга, 2009 - 2012 онд Монгол Улсын Шүүхийн Сахилгын хорооны гишүүн, 2008 - 2012 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Шашны Зөвлөлийн гишүүн, 2012 - 2016 онд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дахь МАН-ын бүлгийн ажлын албаны дарга, 2016 оноос Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, Нийслэлийн Засаг даргын Ногоон хөгжил, агаарын бохирдлын асуудал хариуцсан орлогчоор ажиллаж байна.



УЛААНБААТАР ХОТЫН АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛЖ, ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРЛЫГ БАГАСГАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Олон жилийн дунджаар Улаанбаатар хотын агаарын температур 2.6°C-р дулаарсан нь улсын дунджаас 30%-иар их байна. Цөлжилт, ган зуд, байгалийн гамшигт үзэгдлийн тоо, давтамж нэмэгдэх хандлагатай байгаа нь урт болон дунд хугацаанд уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг даван туулах, дасан зохицох чадавхыг бэхжүүлэх шаардлагыг бий болгож байгаа юм.

Улаанбаатар хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн тасралтгүй нэмэгдэж, түүнээс үүдэн агаар, хөрс, усны бохирдол, орчны доройтол, инженерийн болон нийгмийн дэд бүтцийн хүрэлцээгүй байдал, авто замын түгжрэл, гэр хорооллын төлөвлөлтгүй тэлэлт зэрэг тулгамдсан асуудлууд бий болсон. Агаарын бохирдлын түвшин сүүлийн 10 жилд эрс нэмэгдэж агаар дахь хүхэрлэг хий болон азотын давхар ислийн агууламж 2,6-3,1 дахин өссөн. Улаанбаатар хотоос агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, Улаанбаатар хотын суурьшлын болон агаарын чанарыг сайжруулах бүсийг шинэчлэн тогтоох, тусгай дэглэмийг мөрдүүлэх, түүхий нүүрсний хэрэглээг хориглох, инженерийн дэд бүтцийг өргөтгөх, бүтээн байгуулалт, тээврийн салбарын шинэтгэлийг эрчимжүүлэх зэрэг зоримог шийдвэрүүдийг гарган хэрэгжүүлж байна.

Хэлэлцүүлгийн зорилго

- Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр Улаанбаатар хотын хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагааны үр дүнг танилцуулах, хэлэлцэх
- Бүс нутгийн хотуудын агаарын бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, үр ашигтай технологийн шийдлүүдтэй танилцах, нэвтрүүлэх боломжийг судлах



Ноён Жан Чин

Ардын төлөөлөгчдийн хурлын Байнгын хорооны орлогч дарга БНХАУ-ын Бээжин хот

Тэрбээр Хятадын Коммунист Намын сургуулийг эдийн засаг, менежментийн мэргэжлээр дүүргэсэн. Одоо Бээжин хотын Ардын төлөөлөгчдийн хурлын Байнгын хорооны болон намын бүлгийн дэд даргын албыг хашиж байна.

Жан Чин өмнө нь Бээжин хотын Чао-Ян дүүргийн Прокурорын газрын орлогч дарга, ХКН-ын Бээжин хот дахь Зохион байгуулалт, судалгааны газрын хэлтсийн дарга, орлогч дарга, Бээжин хотын Боловсон хүчний институтийн дэд захирал, мөн тус хотын Намын хорооны Зохион байгуулалтын газрын Гадаад хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулагыг хариуцсан хэлтсийн дарга зэрэг албан тушаалыг хашиж байв. Түүнчлэн Бээжин хотын Намын хорооны нарийн бичгийн дарга, Бээжин хотын Ардын их хурлын Байнгын хорооны орлогч нарийн бичгийн дарга, Гадаад харилцааны албаны дарга, Тамгын газрын даргаар ажиллаж байсан туршлагатай.



БЭЭЖИН ХОТЫН АГААРЫН БОХИРДЛЫН ХЯНАЛТЫН ТОЙМ: 2013-2017

Хятад Улсын нийслэл хотын хувьд, Бээжин хот нь нүүрстөрөгч багатай хотын хөгжлийн чиглэлд тэргүүлж байгаа билээ. 2013 онд Хятад улсын баталсан Агаарын бохирдлоос урьдчилан сэргийлэх, хянах үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор Бээжин хот агаарын бохирдлыг хянах цогц хөтөлбөр буюу Бээжин хотын Цэвэр агаар үйл ажиллагааны төлөвлөгөөг (2013-2017) боловсруулж агаар дахь PM2.5-ын бохирдлыг бууруулахад голчлон анхаарсан. Тус төлөвлөгөөний дагуу Бээжин хот нь эрчим хүч, авто тээврийн хэрэгсэл болон аж үйлдвэрийн бүтцийг сүүлийн 5 жилд оновчтой болгон сайжруулсан билээ. Эдгээр хүчин чармайлтын ачаар Бээжин хотын агаарын чанар тасралтгүй сайжирч, нийгмийн ашиг тус, эдийн засгийн үр өгөөж, байгаль орчны тогтвортой байдалд хүрч чадсан. Бээжин хот агаарын бохирдлоос урьдчилан сэргийлэх, түүнд хяналт тавих туршлагаасаа бусад хотуудтай хуваалцахдаа таатай байх болно.

Сүүлийн жилүүдэд агаарын бохирдлын хяналтыг томоохон хэмжээнд, чанартай хэрэгжүүлснээр, Бээжин хотын агаарын бохирдлын гол эх үүсвэрт нүүрсний хэрэглээ тооцогдохоо больсон юм. Гэсэн хэдий ч авто тээврийн хэрэгсэл, тоосжилтоос үүдэлтэй бохирдлууд одоог хүртэл байсаар байна. Агаар дахь PM2.5-ын сүүлийн үеийн дүн шинжилгээгээр хөдөлгөөнт эх үүсвэр №1 буюу нийт эх үүсвэрийн 45%-г дангаараа эзэлж байна. Тус форумд оролцож буй зорилго нь агаарын бохирдлоос урьдчилан сэргийлэх, хянах үйл ажиллагааны чиглэл, авч хэрэгжүүлсэн ажлын туршлагаас хуваалцах болон бусад улс орнуудын туршлага, тэр дундаа хөдөлгөөнт эх үүсвэр болон дэгдэмхий органик нэгдлүүдийг хянахад авсан арга хэмжээний талаар мэдээлэл авах юм.



Ноён Кихюүн Ким

Гадаад харилцааны газрын дарга
БНСУ-ын Сөүл хот

Ноён Ким 2017 оны 1-р сараас Сөүл хотын захиргаанд Гадаад харилцааны газрын даргаар ажиллаж байна. 2015-2017 оны хооронд АНУ-д 2 жилийн мэргэжлийн сургалтад хамрагдаж байсан бөгөөд түүнээс өмнө БНСУ-н Урлаг, спорт, аялал жуулчлалын яаманд томилогдон ажиллаж байсан юм. Мөн 2013-2014 оны хооронд Соёл ба загварын захиргаанд Аялал жуулчлалын бизнесийн газрын даргаар ажиллаж байжээ.

Харин 2011-2013 онд Эдийн засгийн төлөвлөлтийн захиргааны Нийгмийн шинэчлэлийн товчоо болон Эдийн засгийн бодлогын багийн дор Шинэчлэл төлөвлөлтийн багийн ахлагчаар ажиллаж байв. Ким нь БНСУ-н Солонгосын их сургуулийн Олон нийтийн захиргааны бакалаврын зэрэгтэй бөгөөд Их Британий Бирмингэмийн их сургуулийг Эдийн засгийн хөгжил ба бодлогын дүн шинжилгээ чиглэлээр магистрын зэрэгтэй төгссөн.



СӨҮЛ ХОТЫН АГААРЫН ЧАНАРЫН ХЯНАЛТЫН БОДЛОГУУД

БНСУ-ын нийслэл Сөүл хот нь цахим засаглал, эдийн засаг болон харилцаа холбоо, мэдээллийн технологийн хөгжил дэвшлээр дэлхий дахинд өндөр үнэлэгддэг. Харин агаарын чанар, ялангуяа тоосонцрын бохирдол нь Сөүл хотын хувьд хүндхэн сорилт болоод байгаа бөгөөд энэ асуудлыг шийдэх оновчтой арга замыг олоогүй байна. Иргэд оршин суугчид мөн тоосонцрын бохирдолд өндөр ач холбогдол өгч байгаа бөгөөд Сөүл хотын захиргаа иргэдийн дуу хоолойг сонсож, тэдгээрийн санал хүсэлт дээр тулгуурласан цэвэр агаарыг хамгаалах, агаарын чанарыг сайжруулахад чиглэсэн хоёр бодлого боловсруулсан.

Энэхүү танилцуулгаар Сөүл хотын захиргаанаас гаргасан агаарын бохирдолтой тэмцэх, цэвэр агаартай байлгахад чиглэсэн 10 бодлогоо танилцуулах юм. Үүнд: тээврийн хэрэгсэл дээр шошго тэмдэг байрлуулж ялгах, утаа болон агаарын бохирдол ялгаруулалт хязгаарласан бүс тогтоож шаардлага хангаагүй тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хорих, азотын ислийн хэмжээ багатай шатаагч, бойлер ашиглах, агаарын чанарын хяналтыг сайжруулах судалгаа шинжилгээ зэрэг өргөн хүрээний бодлогууд багтаж байгаа юм. Үүний зэрэгцээ энэхүү танилцуулгад иргэдийн оролцоо санаачилга дээр тулгуурласан арга хэмжээнүүд багтсан болно.

Хэлэлцүүлгийн явцад дараах асуудлыг авч хэлэлцэхийг санал болгож байна:


- (1) Чуулга уулзалтад оролцогч хотууд агаарын бохирдолтой тэмцэх өөрсдийн арга барил, практик туршлагаасаа хуваалцах
- (2) Тоосонцрын бохирдолтой тэмцэх иргэдийн санаачилга оролцоотой арга хэмжээний талаар санал бодлоо солилцох
- (3) Агаарын чанарыг хамгаалах дэлхий нийтийн хамтын санаачилгуудын талаар ярилцах болно.



Ноён Наобүми Хигашикава

Байгаль орчны газрын Уур амьсгалын
өөрчлөлт ба эрчим хүчний хэлтсийн дарга
Япон Улсын Токио хот

Наобүми Хигашикава нь Токио хотын Захиргааны Хүлэмжийн Хийн Ялгарлын худалдааны хөтөлбөрийн захирлын албыг хашиж байна. Хүлэмжийн хийг 25 хувиар бууруулж чадсан дэлхийн анхны “ХХЯ-ын худалдаа” хөтөлбөрийн захирал Наобүми нь хөтөлбөрийн худалдан авах схемийг хариуцаж мөн хөтөлбөрийн 3-р үе шатны боловсруулалт зорилтыг тодорхойлоход гар бие оролцон ажиллаж байна.



Тэрбээр 1994 оноос Токио хотын Захиргаанд ажиллаж эхэлсэн бөгөөд өмнө нь диоксингүй хог хаягдлыг шатаах үйлдвэрийн төсөл дээр ажиллаж байсан туршлагатай. Мөн байгаль орчны чиглэлээр Дизель тээврийн хэрэгслийн ялгаруулалтыг хянах чиглэлээр ажилласнаар Токиогийн агаарын чанарыг сайжруулахад ихээхэн хувь нэмэр оруулжээ. Тэрбээр дизель тээврийн хэрэгслээс ялгарч буй утааг хянах эрх зүйн схем боловсруулж, хөрш зэргэлдээ хотуудтай сайн түншлэлийг бий болгох зэрэг төсөл хөтөлбөрт 10 гаруй жилийн турш ажилласан юм. Дуу чимээ, чичиргээ, замын түгжрэлийн менежмент зэрэг тээврийн хэрэгслийн талаарх өргөн мэдлэг, баялаг туршлага нь түүнийг Токио хотын тээврийн хэрэгслийн бохирдлын хяналтын шилдэг мэргэжилтэн болгожээ.



ТОКИО ХОТЫН НҮҮРСТӨРӨГЧИЙГ БУУРУУЛАХ САНААЧИЛГУУД

Тогтвортой хотод харилцан ашигтай байдлыг бий болгох

Токио хотын захиргаа нь 1960 оноос хойш байгаль орчны маш олон асуудлын шийдлүүд дээр ажиллаж байсан ба үүний үр дүнд агаар, усны чанарыг багагүй хэмжээгээр сайжруулсан. Бодлогын хэрэгжилтийн явцад оролцогч талуудаас маш их эсэргүүцэлтэй тулгардаг байсан хэдий ч 1) шат дараалсан алхмууд, 2) бохирдуулагч бодисын шинжлэх ухааны дүн шинжилгээ, зорилтот байгууламж болон оролцогч тал, санаачилгын тооцоолсон үр дүн, 3) олон бодлогуудын нэгэн зэрэг хэрэгжүүлсэн байдал нь Токиогийн байгаль орчны асуудлыг сайжруулахад маш их түлхэц болсон.

Хүний буруутай үйл ажиллагаанаас маш их хэмжээний хүлэмжийн хий ялгарч, дэлхийн дулаарлыг үүсгэж байгаа бөгөөд энэхүү дулаарал нь ган зуд, аадар борооны шалтгаан болж байгаа юм. Харин эдгээр байгалийн үзэгдэл нь хөдөө аж ахуй болон загасны аж ахуйд нөлөөлөөд зогсохгүй хот суурин газарт мөн нөлөөлж эхлээд байна.

2010 онд Токио хотын Захиргаа нь хүлэмжийн хийн ялгарлын худалдаа хөтөлбөрийг хэрэгжүүлж, томоохон байгууламжуудад хүлэмжийн хийг бууруулах зорилтыг хэрэгжүүлэх шаардлагыг тавьсан. Энэхүү хөтөлбөр нь дэлхийн хамгийн анхны хүлэмжийн хийн худалдааны схем бөгөөд үүндээ хотын оффисын барилгыг хамруулсан байдаг. Токио хотын Захиргаа нь уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр маш олон санаачилга хэрэгжүүлдгийн нэг нь энэхүү хүлэмжийн хийн ялгарлын худалдаа хөтөлбөр юм.



Хатагтай Полина Захарова

Байгаль орчныг хамгаалах хүрээлэнгийн Захирал ОХУ-ын Москва хот

Полина Захарова 2012 оны 9-р сараас “Мосэкомониторинг” Төрийн байгаль орчны хамгааллын хүрээлэнд ажиллаж байна. Москва хотын захиргаа тус хүрээлэнг 2001 онд байгуулсан. Хатагтай Захарова байгаль орчны хяналт мониторингийн салбарт 16 жил ажилласан туршлагатай бөгөөд гадна орчны агаар, ус, хөрс, дуу чимээний төвшинд байгаль орчны хяналт тавих төсөл хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлэх, байгаль орчны хяналтын дата мэдээлэлд үндэслэсэн шийдвэр гаргалт, хэрэгжүүлэлтийн ажилд хувь нэмрээ оруулдаг.

Тэрбээр Москва хотын байгаль орчны стратеги төлөвлөгөө боловсруулах, хотын байгаль орчны тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд идэвхтэй оролцож өөрийн үнэтэй хувь нэмрийг оруулсан. Хатагтай Захарова ОХУ-н Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Техникийн шинжлэх ухааны доктор зэрэгтэй. Москва хотын захиргаа болон ОХУ-н Байгалийн баялаг, экологийн яамнаас олон тооны хүндэт жуух бичиг, шагналыг хүртсэн нэгэн юм.



МОСКВА ХОТЫН УУР АМЬСГАЛЫН БОДЛОГЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД

Уур амьсгалын бодлогын нийтлэг чиглэлүүд нь дэлхийн улс орнууд, аж үйлдвэрийн салбарууд, нийгмийн зүтгэлтнүүд, шинжлэх ухааны нийгэмлэгүүдийг хамтран ажиллахад хүргэж байна. Учир нь бид бүгд байгаль орчны бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох орчин үеийн арга замыг хөгжүүлэхийг хичээж байгаа юм. Москва хот олон улсын тогтвортой хөгжлийн зорилтод хүрэх үүрэг амлалтаа тууштай байгааг хэрэгжүүлж буй үйлдэл, авч буй арга хэмжээнээс нь харж болно. Москва хот нь 2006 онд “С40 Хотууд - Уур амьсгалын манлайлагчдын бүлгэм”-д Оросын хотуудаас анх удаа нэгдсэн бөгөөд одоог хүртэл уг бүлгэмд нэгдсэн Оросын цор ганц хот байсаар байна. Түүнчлэн 2016 онд Олон улсын Цаг уур, эрчим хүчний зөвшилцөлд нэгдэн орсон нь Москва хот дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг олон улсын санаачилгыг дэмжиж буйг илэрхийлсэн явдал болсон юм. Мөн уур амьсгалын өөрчлөлтийн хүрээнд Москва хот хоёр тэргүүлэх зорилттой: Нэгд, уур амьсгалд үзүүлэх гадны нөлөөлийг бууруулах (хүлэмжийн хийн ялгарлыг багасгах), хоёрт, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох юм. Тийм ч учраас Москва хот сэргээгдэх, уламжлалт-бус, хоёрдогч эрчим хүчний хэрэглээгээ нэмэгдүүлсээр байна.

Энэхүү хэлэлцүүлгээр Москва хотын удирдлагаас байгаль орчны аюулгүй байдал, бохирдлын хяналт, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чиглэлээр гаргаж буй томоохон хүчин чармайлтуудыг танилцуулах; оролцогч хотуудтай мэдлэг, туршлагаасаа хуваалцах; шинээр харилцаа холбоо, хамтын ажиллагаа тогтоох зэрэг асуудлыг хөндөнө.



НҮҮРСТӨРӨГЧ БАГАТАЙ ХОТУУДЫН ТЕХНОЛОГИЙН ШИЙДЛҮҮД БА САЙН ТҮРШЛАГУУД

ХОЁРДУГААР ХУРАЛДААН:

Хатагтай Санжаасүрэнгийн Оюун

Гадаад харилцааны асуудал хариуцсан захирал
Уур амьсгалын ногоон сан

Санжаасүрэнгийн Оюун нь Ногоон Уур амьсгалын сангийн Гадаад харилцааны асуудал хариуцсан захирлын ажилд томилогдон ажиллаж байна.

С.Оюун нь Дэлхийн усны түншлэл олон улсын байгууллагын TVЗ-ын Дарга, НҮБ-ын Байгаль орчны Ассемблейн анхны Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүн (1998-2016), Байгаль орчин, Ногоон хөгжлийн болон Гадаад харилцааны сайдаар ажиллаж байсан.

С.Оюун нь ардчилал, сайн засаглал, залуучуудын боловсролын чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг Монголын тэргүүлэх ТББ болох Зориг сангийн үүсгэн байгуулагч бөгөөд тэргүүнээр ажилладаг. Тэрбээр мөн Монголын Тусгай Олимпын хороо болон дэлхийн эмэгтэй захирлуудын нийгэмлэгийн Монгол дахь салбарын (Эмэгтэй Захирлуудын Клуб) удирдах зөвлөлийн тэргүүний албыг хашдаг.

С.Оюун нь Чарласын Их Сургуулийг геохимич мэргэжлээр төгссөн бөгөөд Кэмбрижийн Их Сургуульд докторын зэрэг хамгаалсан. Монгол, Англи, Орос болон Чех хэлтэй.



УЛААНБААТАР ХОТЫН АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ АРГА ЗАМ, ТЕХНОЛОГИЙН ШИЙДЛҮҮД

- Дэлхийн нийт хүн ам PM2.5 нарийн ширхэгт тоосонцорт өртөх байдал 1990 оноос хойш 11.2%-иар өссөн байна.
- PM2.5 агууламж ихэнх хотуудад (87.3%) ДЭМБ-аас зөвшөөрсөн жилийн дунджаас ($10\mu\text{g}/\text{m}^3$) байнга хэтэрсэн байдаг.
- Эрчим хүчний салбар нийт хүлэмжийн хийн ялгарлын NOx -ын 70%, PM2.5 90%-ийг ялгаруулдаг.


Улаанбаатар хотын гэр хороолол нь анх суурин газрын төлөвлөлттэй байгаагүй юм. Улаанбаатар хотын төвөөс тэлэх гэр хороолол нь бэлтгэлгүй төлөвлөлт, эдийн засгийн боломжийг эрэлхийлэх хөдөө орон нутгаас хот руу маш ихээр ирэх болсон шилжин суурьшигчид, хяналтгүй хотжилтын үр дүн боловч энэ нь мөн байгалийн гамшиг, зүгээр мал аж ахуйгаас алдсанаас шалтгаалсан байдаг.

Монгол улс уур амьсгалын өөрчлөлтөд үзүүлж буй нөлөө багатай ч маш ихээр өртсөн улс юм: агаарын температур 2.20C-аар өссөн нь дэлхийн дунджаас даруй 2 дахин их байгаа юм. Дэлхийн дулаарал нь агаарын температурт нөлөөлөхөөс гадна цөлжилт, бэлчээрийн талхлалт, мөнх цаст, мөсөн гол хайлж байгаа зэрэг олон уршгийг дагуулж байна.

Шийдэл, арга зам

- ЗАСАГЛАЛ, улс төрийн хүсэл эрмэлзэл, олон нийтийн оролцоо
- Нүүрстөрөгч багатай зуух
- Цэвэр түлш (хагас коксжуулсан шахмал түлш г.м)
- Цахилгаан болон хийн халаагуур
- Дулаалга, эрчим хүчний хэмнэлттэй барилга
- Гэр хорооллын дахин төлөвлөлт /дэд бүтэц
- Орон сууцанд шилжин суурьших /ипотекийн зээлийн схем
- Сэргээгдэх эрчим хүч (гүний дулаан)

Аливаа асуудлын шийдэл нь хүртээмжтэй байж, бүх нийтийн амьдрал, амьжиргаа болон эрүүл мэндийг сайжруулахад төвлөрч, байгалийн тогтолцоог хүндэтгэхэд оршино.



Ноён Арнауд Хэкманн

Хотын хөгжил хариуцсан ахлах мэргэжилтэн
Азийн Хөгжлийн Банк

Арнауд Хэкманн нь Нийгэм судлалын гүнзгийрүүлсэн сургуульд харьцуулсан хөгжлийн судалгаагаар магистр, Тулузын Их Сургуульд хүн амын газарзүйгээр мөн магистрын зэрэг тус тус хамгаалсан. Одоогоор Азийн хөгжлийн банкны Зүүн Азийн салбарын хотын хөгжил хариуцсан ахлах мэргэжилтнээр ажиллахын зэрэгцээ Хятад, Монгол зэрэг орнуудын хотын болон бүсийн хөгжлийн төслүүдэд техникийн туслалцаа үзүүлдэг.

Тэрбээр Азийн Хөгжлийн Банканд ажиллахаасаа өмнө Дэлхийн Банк, АфД, Эдийн засгийн хөгжил, хамтын ажиллагааны байгууллага зэрэг олон улсын байгууллагуудад хотын болон бүс нутгийн дэд бүтцийн дизайн, хэтийн дүн шинжилгээ, хөгжлийн хувилбарууд боловсруулах төслүүдийг ахлан ажиллаж байсан туршлагатай.



“УЛААНБААТАР ХОТЫН ИРГЭДИЙН ОРЛОГОД НИЙЦСЭН НОГООН ОРОН СУУЦ БА ДАСАН ЗОХИЦОХ ЧАДВАР БҮХИЙ ХОТЫН ШИНЭЧЛЭЛ” ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Улаанбаатар хотын гэр хороолол зохион байгуулалтгүй, төлөвлөлтгүй орчинд өргөжин, тэлсээр ирсэн. Ийнхүү гэр хороолол цар хүрээгээ тэлж буйд хямд төсөр орон сууцны хүрэлцээ хангалтгүй, орон нутгаас хот руу шилжих хөдөлгөөн их зэрэг хүчин зүйлс нөлөөлсөн бөгөөд дулааны алдагдал ихтэйгээс үүдэн нүүрс хүчлийн хий, агаарын бохирдлын үндсэн эх сурвалж болсоор байна. Иймд иргэдийн худалдан авах чадварт нийцсэн, дулааны алдагдал багатай, агаарын хэмд мэдрэмхий бус, байгаль орчинд ээлтэй орон сууцны загварыг бий болгох, дагалдах бүтцийг хөгжүүлэх шаардлагатай байна.

Энэхүү илтгэлээр гэр хороололтой холбоотой урган гарч буй асуудлуудыг шийдвэрлэх, цогц, хямд төсөр ногоон орон сууц, орчны шийдэл бий болгох чиглэлээр Монгол Улсын Засгийн газар, Барилга хот байгуулалтын яам, Монгол Улсын Хөгжлийн Банк, Азийн Хөгжлийн Банк, Уур амьсгалын ногоон сангийн хамтран хэрэгжүүлж буй хөтөлбөр болох 1) Дахин сэргээгдэх эрчим хүч голмон ашиглах 10,000 ногоон байшин барих, 2) 100 га газрыг байгаль орчинд ээлтэй, агаарын бохирдол багатай, орчин үеийн, жишиг гэр хороолол бий болгох, дахин төлөвлөх ажиллагаанд хувийн салбарын хөрөнгө оруулалтыг татах санаачилгыг танилцуулах болно.

Хөтөлбөрийн хүрээнд гэр хорооллын хөгжил, ногоон орон сууц барих барилгын материал, технологи, салбарын бодлого, институцийн чадавхыг сайжруулж, иргэд болон нийгмийн оролцоог ханган, эдийн засгийн боломж нээсэн хот төлөвлөлтийн цогц бодлого бий болгохыг зорьж байна.



Ноён Жау Юншэнг

Ардын Засгийн газрын
Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч
БНХАУ-ын Шэньян хот

Жау Юншэнг нь 2007 онд БНХАУ-ын Цинхуа их сургуулийг төгссөн ба 2008-2010 онд тус сургуулийн хуулийн тэнхимд суралцаж төгссөн. 2017 оны 12-р сараас Шэньян хотын Ардын Засгийн газрын Ерөнхий нарийн бичгийн даргын орлогчоор ажиллаж байна. Өмнө нь тэрбээр Цинхуа их сургуулийн судалгааны хүрээлэнгийн гишүүн, Шэньян Пүхэ шинэ хотын бодлогын судалгааны газрын дэд захирлаар ажиллаж байсан туршлагатай.



2012 оноос 2013 оны хооронд Шэнбэй шинэ дүүргийн Шинлонгтай дэд дүүргийн намын нарийн бичгийн даргын орлогч, мөн тус дүүргийн нийгмийн удирдлага ба олон нийтийн үйлчилгээний төвийн намын нарийн бичгийн даргын орлогчийн албыг хашжээ. 2013 оноос эхлэн Тиешу дүүргийн засаг даргын орлогч, Хятадын коммунист залуучуудын холбооны Шэньян хот дахь нарийн бичгийн даргын орлогчоор тус тус ажилласан. 2015 оноос эхлэн Шэньян Газ компанийн ерөнхий менежерийн орлогчоор 1 жил гаруй ажилласан байна.

ШЭНЬЯН ХОТЫН НҮҮРСТӨРӨГЧ БАГАТАЙ ХӨГЖЛИЙН ШИЙДЭЛ БА АСУУДЛУУД

Сүүлийн жилүүдэд эрс тэс цаг уурын аюултай үзэгдэл, туйлын мөс эрчимтэй хайлах, далайн усны түвшин нэмэгдэх зэрэг уршиг дагуулж буй дэлхийн дулаарал нь олон улсын анхаарлын төвд орлоо. Уур амьсгалын өөрчлөлт нь дэлхий дахины бүх хүмүүст тулгарч буй томоохон асуудал юм. Парисын хэлэлцээр уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг сааруулж, ногоон буюу нүүрстөрөгч багатай хөгжлийн замналыг дэвшүүлсэн бөгөөд эргэлт буцалтгүй дагах ёстой гэдгийг харуулсан. Үүнд БНХАУ өндөр хариуцлагатай оролцогч тал байсаар ирсэн бөгөөд нүүрстөрөгчийн ялгаруулалтыг багасгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч 2030 онд нүүрстөрөгчийн давхар ислийн хэмжээний дээд хязгаарт хүрэх зорилготой, 2030 оноос ч өмнө хүрэхээр хичээж байна. Зүүн хойд Азийн төв хот, мөн хүнд үйлдвэрлэлийн томоохон цэгүүдийн нэг болох Шэньян хот нүүрстөрөгч багатай бүтээн байгуулалтыг зорилгоо болгож, хотын тогтвортой байдлыг хангахын тулд бүхий л арга хэмжээг авч байна.

Шэньян дахь нүүрстөрөгч багатай хөгжил, бүтээн байгуулалт, хот төлөвлөлттэй холбоотой асуудал, шийдэл, туршлага хуваалцах замаар дараах сэдвүүдээр хэлэлцүүлэг, санал бодол солилцоно:

1. Хотын бүтээн байгуулалтыг шинжлэх ухааны үндсэн дээр төлөвлөх
2. Үйлдвэрийн барилга байгууламжийг шинэчлэн сайжруулах
3. Эрчим хүчний барилга байгууламжийг оновчтой шийдэх
4. Хотын орчин болон экологийн тогтолцоог сайжруулах



Ноён Еүнчүл Лий

Олон улсын харилцааны асуудал эрхэлсэн Элчин сайд БНСУ-ын Тэжон хот

Тэрбээр 1989 онд Солонгосын их сургуулийг Английн уран зохиолын чиглэлээр төгссөн ба 1992, 1994 онуудад АНУ, Испани улсуудад мэргэжил дээшлүүлжээ. 1990 оноос эхлэн Гадаад харилцааны яаманд ажиллаж эхэлсэн бөгөөд 2005-2008 онд Итали дахь БНСУ-ын элчин сайдын яаманд зөвлөхөөр ажиллаж байв. Үүний дараа Гадаад харилцааны яамны Төв болон Өмнөд Америкийн орнуудын товчоонд захирал, Соёлын солилцоо, хамтын ажиллагааны хэлтсийн даргын албыг тус бүр нэг жилийн хугацаанд хашсан байна.

2010 оноос 2013 он хүртэл Бостон дахь БНСУ-ын Ерөнхий Консулын газрын Консулаар ажилласныхаа дараа тэрбээр Эквадор улс дахь БНСУ-ын Бүрэн эрхт элчин сайдын албыг 2018 он хүртэл хашсан юм. Харин 2018 оноос одоог хүртэл Тэжон хотын Олон улсын харилцаа эрхэлсэн Элчин сайдаар ажиллаж байна.



ТЭЖОН ХОТЫГ АГААРЫН ЧАНАРЫН ЗАГВАР ХОТ БОЛГОХ АРГА ЗАМ

1. Үндэслэл

- Тэжон хотын агаар дахь нарийн ширхэгт тоосонцорт дүн шинжилгээ хийн дизель хөдөлгүүрт авто тээврийн хэрэгсэл, барилгын машин механизм нь эдгээр нарийн ширхэгт тоосонцорыг хамгийн ихээр ялгаруулдгийг тогтоосон (86%)
- Үүний үр дүнд авто тээврийн хэрэгслээс үүдэх нарийн ширхэгт тоосонцорыг бууруулахад чиглэсэн цогц төлөвлөгөө боловсруулах шаардлага гарсан.

2. Зорилго

- Солонгосын том хотуудын дунд хамгийн сайн агаарын чанартай загвар хот болох
- Агаар дахь нарийн ширхэгт тоосонцрын (PM2.5) хэмжээг 2020 он гэхэд 18 мг/м³ болгох

3. Авч буй арга хэмжээ

- 1) Засаглалыг бэхжүүлэх
 - Зөвлөх байгууллага бий болгох
 - Агаарын чанарыг автоматаар сэрэмжлүүлэх тогтолцоог бий болгох
- 2) Агаарын чанарын хамтарсан төслүүд
 - Агаарын бохирдлын хяналтын системийг турших
 - Цэцэрлэгт хүрээлэн болон ногоон байгууламжийг холбох “Ногоон зам”-ыг бий болгох
 - “Бага нөлөөллийн хөгжил (LID)”-ийн техникийг нэвтрүүлэх
 - Иргэдэд ногоон эрчим хүчний хэрэглээгээ нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх (жижиг нарны хавтан г.м)
- 3) Иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх
 - Агаар бохирдуулж буй авто тээврийн хэрэгслийн тоог бууруулах
 - Нийтийн тээврийн хэрэглээг дэмжих



Ноён Олег Кузнецов

Хотын дарга
ОХУ-ын Чита хот

Кузнецов Олег Василевич нь дулааны шугам сүлжээ, цахилгаан станцын инженерийн мэргэжилтэй бөгөөд 2016 онд Оросын Холбооны Улсын Чита хотын захирагчаар томилогдсон. Түүнээс өмнө хотын даргын тэргүүн орлогч, хотын захиргааны нэгдүгээр орлогч дарга, хотын захиргааны хотжилтын асуудал хариуцсан нэгдүгээр орлогч дарга зэрэг албан тушаалыг хашиж байсан. Түүнчлэн Чита хотын дулааны шугам сүлжээний Чито Энерго компанийн орлогч дарга, ерөнхий захирлын албыг хашиж байсан туршлагатай.



ЧИТА ХОТЫН ГАДААД ОРЧНЫ АГААРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ: АГААРЫН БОХИРДЛЫН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМУУД

Чита нь Забайкальский засаг, захиргааны бүсийн нийслэл бөгөөд их газрын эрс тэс, хуурай уур амьсгалтай, хур тунадас бага, жилийн ихэнх өдөр нь нартай хот юм. Тус хот нь ерөнхийдөө уулархаг, дов толгод дунд, хотгор газар байршдаг тул умардын хүйтэн салхинаас хамгаалагддаг хэдий ч агаарын шилжилт хөдөлгөөн багатай.

Энэ нь агаарын солилцоог хязгаарлаж, өвөл агаарын бохирдол бий болох нөхцөлийг бүрдүүлж байна. Чита хотын хувьд агаарын бохирдол үүсгэгч үндсэн эх сурвалж нь цахилгаан станц, өөрөө явагч тээврийн хэрэгсэл, өрхийн халаагуур, зуух юм.

Агаарын бохирдлыг бууруулах арга замууд

Агаарын бохирдлыг бууруулах чиглэлд Чита хотын захиргаанаас дараах арга хэмжээ авч байна. Үүнд:

- 1) Цахилгаан станцын утааны бохирдлыг бууруулах технологийг сайжруулах;
- 2) Цахилгаан станцын үнсний хаягдлыг бууруулах (CHPP 1 болон CHPP 2 хэмжилтээр);
- 3) Цахилгаан халаагуур суурилуулах;
- 4) Хүчилтөрөгчийн давхар исэл багатай дотоод шаталтын хөдөлгүүр суурилуулах;
- 5) Хотын ногоон бүсийг нэмэгдүүлэх, цэцэрлэгжүүлэх

Хүлээгдэж буй үр дүн

- 1) Цахилгаан станц болон өрхийн зуух, халаагуурт орчин үеийн шүүлтүүр, бохирдол бууруулагч суурилуулах;
- 2) Үйлдвэр, аж ахуйн газарт шүүлтүүр, цэвэршүүлэх системгүй зуух, халаагуур ашиглахыг хориглох;
- 3) Иргэдийн дулааны алдагдал багатай технологийн ашиглалтыг нэмэгдүүлэх, үр ашигтай халаалтын систем нэвтрүүлэх;
- 4) Нийтийн тээврийн сүлжээг өргөтгөх;
- 5) Тролейбусны сүлжээ, дэд бүтцийг хөгжүүлэх;
- 6) Иргэдийг газын хөдөлгүүрт өөрөө явагч тээврийн хэрэгсэл ашиглахыг дэмжих.

Хатагтай Ху Мин

Гүйцэтгэх захирал Инноваци ба ногоон хөгжлийн хөтөлбөр (iGDP)

Тэрбээр Ардын их сургуулиас Эдийн засгийн бакалаврын зэрэг, Цинхуа болон Харвардын их сургуулийн Кеннедийн сургуулийн төрийн захиргааны магистрын зэрэгтэй. Орон нутгийн бага нүүрстөрөгчийн бодлогын дүн шинжилгээ хийдэг, бие даасан бодлогын байгууллага болох Инноваци ба ногоон хөгжлийн хөтөлбөрийн гүйцэтгэх захирал, Чинхуа Брүүкинг төвийн суурин бус ахлах судлаач, Эрчим хүчний шинэчлэлийн ахлах мэргэжилтнээр тус тус ажиллаж байна. Өмнө нь Бага нүүрстөрөгч бүхий эдийн засгийн хөгжил хөтөлбөрийн Захирал, Хятадын Эрчим хүчний сангийн Байгаль орчны менежментийн хөтөлбөрт ажиллаж байв.

Ху Мин нь Хятадын уур амьсгалын бодлого, тогтвортой санхүүжилт, нүүрстөрөгчийг үнэлэх, нүүрстөрөгч багатай хотын хөгжил болон чулуужсан түлшний татаас зэрэг чиглэлээр томоохон судалгаа хийж байжээ. Түүнчлэн “Нүүрстөрөгч бага ялгаруулах хөгжлийн замнал ном”-ыг хамтран бичиж, Хятадын Шилдэг хотын LOGIC хэрэгслийг хамтран зохион бүтээсэн туршлагатай.



ХЯТАДЫН НҮҮРСТӨРӨГЧ БАГАТАЙ, НОГООН ХОТУУД: ОЛОЛТ АМЖИЛТ БА ЦААШДЫН ТӨЛӨВ

Хотжилт, эдийн засгийн хурдацтай хөгжил нь Хятадын хотуудын хүлэмжийн хийн ялгаруулалтыг нэмэгдүүлж байна. Үүр амьсгалын өөрчлөлтийн нөлөөг тодорхойлох, дэлхийн болон бүсийн байгаль орчны засаглалыг дэмжих зорилгоор нүүрстөрөгч багатай хотын хөгжлийг дэмжих нь бодлогын чухал чиглэл болсон. Үүний хүрээнд бид хотуудын нийт гаргасан ахиц дэвшлийг хэмжих, тайлагнах болон дүгнэх зорилгоор Хятадын хотуудын нүүрстөрөгч багатай, ногоон хөгжлийн индекс (LOGIC)-г боловсруулсан билээ. LOGIC нь хотын гүйцэтгэлийг хянах, одоогийн болон ирээдүйн бодлого боловсруулагчдад мэдээлэл өгөх зорилготой.

LOGIC нь тус бүс нутгийн хотуудад нүүрстөрөгч багатай хотын хөгжлийг дэлгэрүүлэхээс гадна хот хоорондын хамтын үйл ажиллагааг дэмжинэ гэдэгт итгэлтэй байна. Энэхүү шинжилгээний арга хэрэгслийг ашиглан хотууд өөрсдийн дэвшлийг үнэлэх, шинэ, боломжит ногоон, нүүрстөрөгч багатай үйл ажиллагааг тодорхойлох, бусад хотуудаас суралцах боломжтой. Мөн бодлого боловсруулагчид LOGIC-ыг ашигласнаар хотуудад нүүрстөрөгч багатай хөгжлийн шийдлийг олж чадна гэж үзэж байна.



Ноён Жае Ёүн Лий

Судалгааны хүрээлэнгийн Ерөнхийлөгч
БНСУ-ын Сувон хот

Тэрбээр Эдийн засгийн ухааны доктор зэрэгтэй бөгөөд 2016 оноос эхлэн одоог хүртэл Сувоны судалгааны хүрээлэнгийн ерөнхийлөгчөөр ажиллахын зэрэгцээ Кёонги Их сургуулийн эмерит профессор, Төвлөрлийг сааруулах үйл явц ба орон нутгийн хараат бус байдлын удирдлагын хорооны гишүүн, Сувон дахь төвлөрлийг сааруулах үйл явц ба орон нутгийн хараат бус байдлын хорооны дарга зэрэг албыг хашиж байна. Үүнээс өмнө Кёонги их сургуулийн Эдийн засгийн тэнхимд 36 жилийн турш профессороор ажиллаж байжээ.

Мөн тэрбээр Кёонги их сургуулийн ахисан түвшний сургуулийн тэнхимийн эрхлэгч, Солонгос улсын орон нутгийн нийтийн болон нийтийн санхүүгийн холбооны Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан туршлагатай.



СУВОН ХОТЫН “ЭКО-МОБИЛИТИ” ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ

2013 оны 9-р сард Сувон хотод “Эко-мобилити 2013” төсөл хэрэгжиж эхэлсэн. Энэхүү төслийн ололт амжилт болон үр дүнг хураангуйлан жагсаавал:

- “Хотын тээврийн ирээдүйн шинэ дүр төрхийг тодорхойлох” боловсронгуй загвар сонгож, тодорхой дэс дараалал, зохион байгуулалттай, системчилсэн сурталчилгаа цацсанаар Эко-мобилитиг өдөр тутмын хэрэглээндээ нэвтрүүлэх соёл дэлгэрсэн
- Уналтад орж доройтсон хуучин төвийн бүсийг сэргээж хотын орчныг сайжруулан өргөжүүлэх боломж бий болгосон
- Иргэд, оршин суугчдын дэмжлэг, идэвхтэй оролцоонд тулгуурласан төслийг амжилттай эхлүүлсэн, тээврийн хэрэгслийн оролцоо маш өндөр буюу 99 хувь байсан, хот суурин газрын төлөвлөлт, бүтээн байгуулалт, үйл ажиллагааны чухал бүрэлдэхүүн хэсэг болсон
- Жуулчид, зочдод чиглэсэн төрөл бүрийн хөтөлбөр бэлдсэнээр сэтгэл ханамжийн түвшнийг нэмэгдүүлсэн
- Төр-хувийн хэвшлийн засаглалын бодлого боловсруулах, төр болон хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд суурилсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх
- Иргэдийн ухамсар ойлголтод нөлөөлснөөр Эко-мобилитиг дэмжих үндэс суурийг бэлдсэн
- Эко-мобилити-гийн талаарх ерөнхий чиг хандлага, сэтгэл ханамж, үнэлэмжийн түвшнийг сайжруулсан.

Эко-мобилити нь замын хөдөлгөөний түгжрэл, ачааллыг бууруулах, орон сууц болон уур амьсгалын асуудалтай тэмцэх боломжит шийдэл юм. Үүний зэрэгцээ иргэд оршин суугчдыг хөршүүдтэйгээ илүү дотно харилцахыг урамшуулан дэмжсэн нийгмийн, идэвхжилтийн хөтөлбөр болох төлөвтэй байгаа. Сувоны анхны Эко-мобилити төслийн загварыг Өмнөд Африк (2015) болон Тайваньд (2017) хэрэгжүүлсэн бөгөөд хүмүүс хөдөлгөөнт байдлын оронд тогтвортой, суурьшсан байдалд илүү анхаарах чиг хандлагатай байна. Эко-мобилити төслийн амжилттай хэрэгжүүлснээс хойш Сувон хот Автомашингүй өдөр, Зогсоолгүй олон нийтийн, ухаалаг дугуйны систем зэрэг Эко-мобилитигийн талаар ойлголт мэдлэгийн түвшнийг нэмэгдүүлэхэд чиглэсэн төрөл бүрийн төсөл хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлсэн.

Хатагтай Бямбаагийн Баярлхам

Үндэсний төслийн зохицуулагч Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр

Бямбаагийн Баярлхам нь Токиогийн Их сургуулийг Тогтвортой хөгжлийн шинжлэх ухаан, Люксембургийн Их сургуулийг Банк, санхүүгийн давхар магистрын зэрэгтэй төгссөн. Тэрбээр Даян Дэлхийн Байгаль Орчны Сангийн санхүүжилтээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр, Монгол улсын Барилга, Хот Байгуулалтын Яамтай хамтран хэрэгжүүлж буй “Монгол улсын барилгын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үндэсний арга хэмжээ төсөл”-ийн Үндэсний зохицуулагчаар 2017 оны 3 дугаар сараас хойш ажиллаж байна.

Байгаль орчны эдийн засаг, банк санхүүгийн чиглэлд 10 гаруй жилийн туршлагатай тэрбээр 2015 онд Люксембург улсын Schrodgers Хөрөнгө оруулалт менежментийн компанид санхүүгийн шинжээч, 2011-2014 болон 2008-2009 онуудад Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын санхүүжилттэй “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай” зээлийн төсөлд байгаль орчны санхүүжилтийн мэргэжилтэн, 2011 онд Япон улсын Токио хотноо Азийн Хөгжлийн Банкны Институтэд судлаач, Япон улсын ОРМАС зөвлөх үйлчилгээний компанид судлаачаар тус тус ажиллаж байжээ.

Түүнчлэн Франкфуртын Их сургуулийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үйл ажиллагаа, ногоон санхүүжилтийн чиглэлээр мэргэшсэн сертификаттай.



“МОНГОЛ УЛСЫН БАРИЛГЫН САЛБАРЫН ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ АРГА ХЭМЖЭЭ” ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Эрчим хүчний салбар Монгол Улсын нийт хүлэмжийн хийн ялгарлын дийлэнх хувийг эзэлдэг хэдий ч барилга байгууламжийн эрчим хүчний ашиглалтыг сайжруулж хэмнэлт бий болгосноор ялгарлыг бууруулах өндөр боломжтой салбар юм. Барилгын салбар нь дангаараа нийт нүүрсхүчлийн давхар ислийн ялгарлын 11 орчим хувийг эзэлж байгаа нь бусад салбаруудаас илүү байна. Гэсэн хэдий ч эцсийн хэрэглэгчдийн нийт эрчим хүчний зарцуулалт болон хүлэмжийн хийн ялгарлын хэмжээний талаар тоо баримт, мэдээлэл хомс байна. Эрчим хүчний хэрэглээ, зарцуулалтыг хэмжих, хянах, харьцуулах суурь үзүүлэлт тодорхойлох хүндрэлтэй байгаа нь ялангуяа эрчим хүчний зарцуулалтыг хэмнэх арга хэмжээнд чиглэсэн хөрөнгө оруулалт татах, норм стандартыг 100 хувь дагаж мөрдөхөд тулгамдаж байна.

Дээрх асуудлыг шийдэх зорилгоор НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд боловсруулсан барилгын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үндэсний арга хэмжээг Монгол Улсын Засгийн газар барилгын салбарын эрчим хүчний зарцуулалтыг хэмнэх, зах зээлийн өөрчлөлт хувьслыг дэмжих цогц шийдэл гэж үзэж байна. Даян дэлхийн байгаль орчныг хамгаалах сангийн санхүүгийн дэмжлэгтэй энэхүү төслийг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр болон Монгол Улсын Барилга хот байгуулалтын яам 2017 оноос хойш хамтран хэрэгжүүлж байна.

Энэ илтгэлээр төслийн зорилго, зорилтууд, хэрэгжүүлэх арга хэмжээ хүрэх үр дүнг танилцуулна. Төслийн хүрээнд одоогоор хийгдэж буй санаачилгуудын нэг болох барилгын салбар дахь хүлэмжийн хийн тооллогын систем, түүний зорилго, аргачлал, бүтэц, зохион байгуулалт болон вебд суурилсан уг тооллогын системийн цахим хуудасны загварыг мөн танилцуулна.



Ноён Александр М.Голков

Хотын дарга
ОХУ-ын Улаан-Үд хот

1991 онд Их сургуулиа төгссөн тэрбээр Зүүн Сибирийн Технологийн сургуульд 2 жил гаруй багшилжээ. Үүний дараа 1994 онд өөрийн хувийн бизнесээ эхлүүлсэн бол 2001 оноос 2007 оны хугацаанд Буриадын Аж үйлдвэр, Бизнес Эрхлэгчдийн Холбоог удирдсан байна.

2003 онд Александр М.Голков Улаан-Үд хотын Депутатын зөвлөлийн гишүүнээр сонгогдож, 2007 оны 12-р сараас Депутатын зөвлөлийн III хурлын даргын албыг хашиж байв. 2009 оны 3-р сараас Улаан-Үд хотын Депутатын зөвлөлийн IV хурлын дарга, Санхүү, эдийн засгийн хорооны даргаар ажилласан ба 2012 оны 12-р сараас одоог хүртэл Улаан-Үд хотын даргаар ажиллаж байна. Мөн тэрбээр ОХУ-ын Төлөөлөгчдийн Холбооны Тэргүүн дэд дарга бөгөөд Бүгд Найрамдах Буриад улсын хүндэт инженер юм.



УЛААН-ҮД ХОТЫН ГАДААД ОРЧНЫ АГААРЫГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ ГОЛ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

Хотын захиргааны албаныхны хувьд агаарын чанарыг сайжруулж, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах нь өрсөлдөх чадвар, эдийн засгийн өсөлт болон нийгмийн эрүүл мэндийн асуудлыг авч үзэх шаардлагатай байдаг. Байгаль орчны хүчин зүйл нь нөлөөллийн нэн чухал хүчин зүйл бөгөөд хотын хөгжлийн тодорхой тэргүүлэх чиглэл, хязгаар, нөхцөлийг тодорхойлдог.

Гадаад орчны бохирдлыг бууруулах асуудлыг шийдвэрлэхэд Улаан-Үд хотын нийгмийн болон эдийн засгийн хөгжлийн Хөтөлбөрт байгаль орчны менежмент, байгаль хамгаалмын асуудлыг тусгасан Улаан-Үд хотын халаалтын нэгдсэн систем болон хот суурин газрын ойн хамгаалмыг авч үзсэн.

Улаан-Үд хотын гадаад орчны агаарыг сайжруулахад хэрэгжүүлж буй арга хэмжээг танилцуулах, оролцогч хотуудтай туршлага хуваалцах болон форумын үеэр танилын хүрээгээ тэлэх явдал юм.



Ноён Си Жэн

Байгаль хамгаалах газрын Дэд дарга БНХАУ-ын Тяньжин хот

Си Жэн нь 1987 онд Тяньжиний Их сургуульд архитекторын бакалавр, 1990 онд Зүүн Өмнөдийн Их сургуульд Архитекторын түүх, онол сэдвээр магистр, 1997 онд мөн тус сургуульд докторын зэрэг хамгаалжээ. 2016 оноос эхлэн одоог хүртэл Тяньжин хотын Байгаль хамгаалах газрын дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байна.

1990-2002 онд Тяньжин Чэнжиан Их сургуулийн Архитекторын коллежид багшилж 1996, 1997, 2002 онд багш, дэд профессор, профессор цолыг тус тус хүртсэн. 1997-2001 онд тэрбээр Тяньжин Чэнжиан Их сургуулийн Архитекторын коллежийн орлогч дарга, 2001-2006 онд тус байгууллагын даргаар ажиллаж байсан туршлагатай.

Түүнчлэн 2006-2013 онд Тяньжин Чэнжиан Их сургуулийн Дэд Ерөнхийлөгч бөгөөд Тяньжин хотын Сичин дүүргийн Улс төрийн зөвлөлдөх уулзалтын дэд даргын үүргийг хавсран гүйцэтгэж байв. 2013-2016 онд тэрбээр мөн тус их сургуулийн Дэд ерөнхийлөгч, Тяньжин хотын улс төрийн зөвлөлдөх уулзалтын Хүн ам, байгалийн нөөц, байгаль орчин болон барилга, хот байгуулалтын хорооны дэд дарга, Тяньжин хотын Сичин дүүргийн Улс төрийн зөвлөлдөх уулзалтын дэд даргын албыг хашиж байсан.



НҮҮРСТӨРӨГЧ БАГАТАЙ ХОТ: БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ БА МЕНЕЖМЕНТ

Хотуудын тогтвортой хөгжлийн чухал хэсэг нь нүүрстөрөгч багатай барилга, бүтээн байгуулалт, менежмент юм. Тус сэдвийн хүрээнд уг илтгэлээр Тяньжин хотын газарзүй, нийгэм, эдийн засгийн байдал, эрчим хүч болон нүүрстөрөгчийн ялгаруулалтыг авч үзэх болно.

Мөн бүтээн байгуулалтыг тэргүүнд, байгаль хамгааллыг удаах тавьдаг загвар хотоос ногоон, нүүрстөрөгч багатай эко, амьдрахад ээлтэй хотыг бий болгосон Тяньжин хотын ногоон хөгжлийн үе шатуудыг авч үзэх юм.

Эрчим хүч, аж үйлдвэр, тээвэр болон барилгын салбарт нэгдсэн ногоон хөгжлийн туршилтын барилгын төслийг нэвтрүүлж, нүүрстөрөгч багатай хотын бүтээн байгуулалт, менежментийг сайжруулахаар ажиллаж байна.

Уг төслийн туршлагыг солилцсоноор форумд оролцогч улс орнуудад мэдээлэл өгөхөөс гадна хот суурин газрын бага нүүрстөрөгч бүхий бүтээн байгуулалт, менежмент хийх талаар задлан хэлэлцэж, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд хотуудын гүйцэтгэх үүргийг тодорхойлох нь хамгийн чухал юм.

Мөн хурлын төлөөлөгчдийн санаа, санаачилгыг сонсож, тэднээс суралцах цаашлаад нүүрстөрөгч багатай хотын бүтээн байгуулалт, менежментийн тал дээр Тяньжин хот бусад хотуудтай хамтран ажиллаж хамтарсан судалгаа хийх, туршлага судлах, тус хотуудын хөгжилд хувь нэмрээ оруулахаар зорьж байна.



ЗҮҮН ХОЙД АЗИЙН ХОТЫН ДАРГА НАРЫН ФОРУМЫН ЦААШДЫН АЛХАМ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АСУУДАЛ ГУРАВДУГААР ХУРАЛДААН:

Ноён Сүрэнгийн Бадрал

Форум зохион байгуулах ажлын хэсгийн зөвлөх

Дипломатч асан С.Бадрал Монгол Улсын Ерөнхий сайдын гадаад бодлогын зөвлөх, Гадаад харилцааны сайдын зөвлөх, Гадаад харилцааны яаманд Тусгай үүрэг гүйцэтгэгч Элчин сайд, Монгол Улсаас НҮБ-ын Бангкок, Женев дэх төвүүдийн дэргэд суугаа Байнгын төлөөлөгчийн орлогч зэрэг албан тушаал хашиж байсан.

Тэрбээр мөн Дэлхийн Худалдааны Байгууллагын Худалдаанд хамаарах хөрөнгө оруулалтын хорооны дарга, Зэвсэг хураах Бага хурлын даргын үүрэг гүйцэтгэгч, Далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын Олон улсын судалгааны төвийн захирлын үүрэг гүйцэтгэгч, Монгол-Хятад-Оросын эдийн засгийн коридорын асуудал хариуцсан Ажлын хэсгийн гишүүнээр тус тус ажиллаж байв.

С.Бадрал ОХУ-ын Москвагийн Олон улсын харилцааны дээд сургууль, АНУ-ын Хавайн Их сургуулийг тус тус магистрын зэрэгтэй төгсжээ.



ЗҮҮН ХОЙД АЗИЙН ХОТЫН ДАРГА НАРЫН ФОРУМЫГ БАЙНГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ МЕХАНИЗМ БОЛГОХ НЬ

Улаанбаатар хот нь 2014 онд Зүүн Хойд Азийн хотын дарга нарын форумыг анх удаа, түүнээс хойш (2016, 2018) гурав дахь удаагаа зохион байгуулж байна. Өөрөөр хэлбэл, энэхүү форум нь 2 жил тутамд тогтмол зохион байгуулагддаг арга хэмжээ болоод байна. Мөн 2015 онд Зүүн Хойд Азийн хотуудын дунд тусгайлсан асуудлаар холбогдох уулзалтыг Улаанбаатар хотод зохион байгуулсан билээ.

Нийслэл Улаанбаатар хотын ивээл дор зохион байгуулагддаг энэхүү форум нь бүс нутгийн хотуудын дунд хотжилт, технологийн дэвшил, ногоон хөгжил, учирч буй хүндрэл, шийдвэрлэх арга замуудын талаар туршлага солилцож, харилцан ярилцах индэр боллоо. Тиймээс энэхүү форумыг албан ёсны статустай холбож, түүний дэргэдэх байнгын ажиглагаатай институцийг бий болгох цаг нь ирсэн гэж үзэж байна.

Энэхүү танилцуулгаар дээрх зорилтыг биелүүлэх боломжтой хувилбаруудыг авч үзэхээс гадна тус форумын үйл ажиглагааг улам боловсронгуй болгож, өгөөжийг нэмэгдүүлэх чиглэлд цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг танилцуулна.



ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Ноён Магнайдоржийн Отгонбаяр

Дарга
Нийслэлийн Засаг даргын Тамгын газар

М.Отгонбаяр нь Сэрүүлэг Их сургуулийг Эдийн засгийн бакалавр, Удирдлагын академийг Төрийн удирдлагын менежментийн магистрын зэрэгтэйгээр төгссөн.

Тэрбээр 2003-2010 онд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Захиргааны хэлтсийн зохион байгуулагч, Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтнээр ажиллаж байсан бөгөөд 2010-2016 оны хооронд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтсийн даргаар ажилласан туршлагатай. 2016 оноос Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргаар ажиллаж байна.





Ноён Эрхэмбаярын Баттулга

Дарга
Нийслэлийн Байгаль орчны газар

Э.Баттулга нь Улсын Багшийн Их Сургуулийн лаборатори дунд сургууль, тус сургуулийн Байгалийн ухааны факультет, Удирдлагын академийн Төрийн удирдлагын сургууль, Австрали улсын Жеймс Кук Их сургуулийг тус тус төгссөн бөгөөд Газарзүйн ухааны болон Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй. 2016 оноос одоог хүртэл Нийслэлийн Байгаль орчны газрын даргаар ажиллаж байна. Ажлын зэрэгцээ Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Математик, байгалийн ухааны сургуульд багшилдаг.

Тэрбээр 2002-2006 онд Зам, тээвэр, аялал жуулчлалын яам, Аялал жуулчлалын газрын мэргэжилтэн, 2006-2016 онд Зам, тээвэр, аялал жуулчлалын яам болон Байгаль орчин, аялал жуулчлалын яамны газрын дарга, орлогч дарга, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргаар ажиллаж байсан туршлагатай.



Ноён Шушингаагийн Сүхбаатар

Дарга
Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын
Гадаад харилцааны хэлтэс

Ш.Сүхбаатар нь ИБУИНВУлсын Сити Бизнес Коллеж болон Лондонгийн Зочид буудлын сургуулийг тус тус дүүргэсэн. Тэрбээр 2016 оны 11-р сараас эхлэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцааны хэлтсийн даргаар ажиллаж байна.

2009-2013 онд Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга, 2006-2008 онуудад Монгол Улсын Ерөнхий сайдын болон Шадар сайдын туслахаар ажилласан туршлагатай.



